



МОНГОЛ УЛС  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА  
БАЯНХОНГОР АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР

АКТ

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БАЯНЛИГ СУМЫН ЗДТГ-ЫН  
ДАРГА Г.МӨНХСҮХ-д

2017.06.22 № 44

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15.2 дугаар зүйлд тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянлиг сумын ЗДТГ-ын 2016 оны санхүүгийн тайлангаар аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянлиг сумын ЗДТГ-ын ажилтан Н.Мөнхбатын цалингийн урьдчилгаа 280,0 мянган төгрөгийг 2016.12.26 өдөр Баянлиг сумын нэмэлт санхүүжилтын 030755402 тоот дансанд тушаасан боловч нэр данс зөрүүтэй учраас буцаж Баянлиг сумын ЗДТГ-ын дансанд ороогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4.-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дэх "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих..." заалт, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь "Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон" гэсэн заалтуудыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг, Цалингийн урьдчилгаа 280,0 мянган төгрөгийг Баянлиг сумын ЗДТГ-ын ажилтан Н.Мөнхбатаар төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын бусад татвар хураамжийн 10030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

Akt Bayanlig.Docx

516756

шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь "Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон" гэсэн заалтуудыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Иргэн Д.Одонтунгалагийн ажилд орсон хугацааг үндэслэн 54 хоногт ногдох ажилгүйдлийн тэтгэмж 2125310 төгрөгийг Д.Одонтунгалагаар төлүүлэн Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн төрийн сан дахь 100030090005 тоот дансанд төвлөрүүлэх.

Хоёр. Аудитаар тогтоосон 2125310 төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан санхүүгийн баримтыг 2017.06.30-ны өдрийн дотор Баянхонгор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дарга Д.Мөнхбат, ерөнхий нягтлан бодогч С.Хонгорзул нарт хариуцуулав.

АУДИТОР

ТОГТООСОН<sup>1</sup>:

М.АЛТАНТУЯА

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА Д.МӨНХБАТ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

С.ХОНГОРЗУЛ

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 26.2-д зөвсөн "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд эерчил саргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай санглыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж зөвсөн бөгөөд хариуцагч албан тушаалтанд хариуцлага нэгдүүлэхээр эрх бүхий албан тушаалтанд санааг хүргүүлнэ



МОНГОЛ УЛС  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА  
БАЯНХОНГОР АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР

АКТ

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЭРҮҮЛ  
МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА Д.МӨНХБАТ-д

2017.02.24 № 44

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15.2 дугаар зүйлд тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийг олгосон байдлыг шалгахад иргэн Д.Одонтунгалаг /вз82062703/ нь 2016 оны 10-р сарын 4-ний өдрөөс 2017 оны 01-р сарын 19 хүртэлх хугацааны ажилгүйдлийн тэтгэмж 2991178 төгрөг авсан боловч 2016 оны 11-р сарын 03-ны өдөр ажилд орсон байна.

Энэ нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 22-р тогтоолоор баталсан "Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох" журмын 4.6.-д "Даатгуулагчийн хууль бусаар ажлаас халагдсаныг шүүхээс тогтоож, түүний ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн олгож, ногдох нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч нь Нийгмийн даатгалын тухай хуульд заасан хувь хэмжээгээр тооцож зохих санд төлсөн тохиолдолд тухайн даатгуулагчийн ажилгүй байх хугацаанд авсан ажилгүйдлийн тэтгэмжийг санд буцаан төлүүлж, тооцоо хийнэ." Мөн заалтын тайлбарын "Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн дагуу ажилгүйдлийн тэтгэмж авагч ажилд орсон тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж олголтыг зогсоодог тул нэг талаас цалин хөлс, орлогыг ажилгүйдлийн тэтгэмжтэй давхардуулан олгохгүй байх..." гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дэх "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих..." заалт, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан

Akt Ндх.Docx

516758

Хоёр. Аудитаар тогтоосон 208157 төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан санхүүгийн баримтыг 2017.02.28-ний өдрийн дотор Баянхонгор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор сумын ЗДТГ-ын дарга Ц.Насанбаяр, нягтлан бодогч Б.Даваажаргал нарт хариуцуулав.

ТОГТООСОН:  
АУДИТОР  М.АЛТАНТУЯА

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН  
ЗДТГ-ЫН ДАРГА  Ц.НАСАНБАЯР  
НЯГТЛАН БОДОГЧ  Б.ДАВААЖАРГАЛ

<sup>1</sup> Акт, албан шваарлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 бусар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шваарлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлэхгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халгах тухай санхүүг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариулагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ



МОНГОЛ УЛС  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА  
БАЯНХОНГОР АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР

АКТ

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2017. 01.15 № 50

БАЯНХОНГОР СУМЫН ЗДТГ-ЫН  
ДАРГА Ц.НАСАНБАЯР-д

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15.2. дугаар зүйлд тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын ЗДТГ-ын 2016 оны санхүүгийн тайлангаар аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор сумын ЗДТГ-ын нягтлан бодогч Б.Даваажаргалын 2016 оны 5-р сарын цалингийн тооцооллыг зөрүүтэй хийж 208157 төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4.-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дэх "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих..." заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь "Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон" гэсэн заалтуудыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Цалингийн зөрүү 208157 төгрөгийг Баянхонгор сумын ЗДТГ-ын нягтлан бодогч Б.Даваажаргалаар төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын бусад татвар хураамжийн 10030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

өгөхөд баримтлах журам"-ын 3.1.3-д "Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон." гэсэн алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү цагийн мөнгөнөөс суутган тооцоогүй ХХОАТ, НДШ-ийн 58.6 мянган төгрөгийг холбогдох албан тушаалтнаар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь Хүү, торгуулийн орлогын 030000947 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актыг барагдуулсан тухай баримтыг 2017.03.30-ны өдрийн дотор Баянхонгор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Богд сумын Сум дундын эмнэлгийн эрхлэгч Ж.Амарзаяа, нягтлан бодогч М.Түмэнжаргал нарт хариуцуулав.

#### АКТ

ТОГТООСОН:

АУДИТОР



М.АЛТАНТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ

Ж.АМАРЗАЯА

НЯГТЛАН БОДОГЧ

М.ТҮМЭНЖАРГАЛ



МОНГОЛ УЛС  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА  
БАЯНХОНГОР АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР

АКТ

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БОГД СУМЫН СУМ ДУНДЫН  
ЭМНЭЛГИЙН ЭРХЛЭГЧ  
Ж.АМАРЗАЯА ТАНАА

2017.01.25 № 15

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Богд сумын Сум дундын эмнэлгийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад нэмэлт санхүүжилтээс ажилчдад олгосон илүү цагийн хөлснөөс ХХОАТ, НДШ суутган тооцоогүй байна.

Дээрх зөрчил дутагдал гаргасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15.1 дэх ".....заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө", 16.1 дэх "Ажил олгогч нь даатгуулагчийн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг түүнд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого олгох бүртээ энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр тооцон суутгаж, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26.1.1-д "Энэ хуулийн 11 дүгээр зүйл, 12.2, 13.1.2-13.1.4, 15.1-д заасан орлогын дүнд мөн хуулийн 23.1-д заасан хувиар, 14.1.1-д заасан орлогын дүнд 23.2.1-д заасан хувиар, 8.1.6, 8.1.7-д заасан орлогын дүнд 23.2.2-т заасан хувиар, 8.1.8-д заасан орлогын дүнд 23.2.3-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага

516127

Хоёр. Аудитаар тогтоосон 280,0 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан санхүүгийн баримтыг 2017.04.15-ны өдрийн дотор Баянхонгор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Баянлиг сумын ЗДТГ-ын дарга Г.Мөнхсүх, нягтлан бодогч Г.Тунгалаг нарт хариуцуулав.

ТОГТООСОН<sup>1</sup>  
АУДИТОР  М.АЛТАНТУЯА

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

ЗДТГ-ЫН ДАРГА Г.МӨНХСҮХ  
НЯГТЛАН БОДОГЧ  Г.ТУНГАЛАГ

<sup>1</sup> Акт, албан шаардлагын бичлэгт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас төвлөсөн албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг уурзгал ажиллас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүмүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага нэгдүүлэхээр эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



МОНГОЛ УЛС  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА  
БАЯНХОНГОР АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР

АКТ

Б4101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БАЯНЛИГ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ С.ЦЭДЭНДОРЖ ТАНАА

2017.08.02 № 29

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад дотуур байрны нэг хүүхдийн хоногийн хоолны нормативт зардлыг 249,9 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан зөрчил илэрлээ.

Дээрх зөрчил дутагдал гаргасан нь Засгийн газрын 2012 оны 106 тоот "Хоолны зардлын дундаж норматив батлах тухай" тогтоолын 3 дахь заалт "Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 2315 төгрөгөөр тогтоосугай" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.3-д "Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон." гэсэн алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хоолны нормативт хэмжээнээс илүү зарцуулсан 249,9 мянган төгрөгийг нягтлан бодогч, нярав, тогооч нараар хувь тэнцүүлэн төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь Хүү, торгуулийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

Akt Bayanlig.Docx

516741

2. Аудитаар тогтоосон 249900 төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан санхүүгийн баримтыг 2017.03.30-ны өдрийн дотор Баянхонгор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Цэдэндорж, нягтлан бодогч Т.Ганхүлэг нарт хариуцуулав.

#### АКТ

##### ТОГТООСОН:

АУДИТОР



М.АЛТАНТУЯА

##### ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ

С.ЦЭДЭНДОРЖ

НЯГТЛАН БОДОГЧ

Т.ГАНХҮЛЭГ